



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~ оны 09 сарын 15-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөх тухай

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ нь урт хугацаагаар гишүүний үүргээ биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон тул Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Банзрагчийн Нандин-Эрдэнэ-г 2022 оны 09 сарын 15-ны өдрөөр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Хоёр. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~ оны 09 сарын 15-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Дамбийжав овогтой Хүрэлбаатар /РД:УХ61111512/-г 2022 оны 09 сарын 15-ны өдрөөс эхлэн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэлх хугацаанд Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсугай.

Хоёр. Шинээр томилогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүн /Д.Хүрэлбаатар/-т Компанийн тухай хууль, холбогдох хууль дүрэм журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Гурав. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Д.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 15-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Хавсралт-1 ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмүүдэд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотой ТУЗ-ийн 2020 оны 05 сарын 14-ний №14 тоот тогтоолоор батлагдсан хороодын бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.

ТУЗ-ийн ДАРГА:

“ГОВЬ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТУЗ-ийн ГИШҮҮД:

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТН2998-2076357

Д.ГЭРЭЛМАА

Д.ХУЛАН

М.БАЯР

Ж.ОЮУНЧИМЭГ


А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР



Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 09 сарын 15-ний өдрийн хурлын
29-р тогтоолын 1-р хавсралт

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод	Бүрэлдэхүүн	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	Д.Хүрэлбаатар
	гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	Ц.Баатарсайхан
Цалин урамшууллын хороо	дарга	Д.Гэрэлмаа
	гишүүн	Т.Камбэ
	гишүүн	Ж.Оюунчимэг
Эрсдэл, аудитын хороо	дарга	М.Баяр
	гишүүн	А.Жаргалмаа
	гишүүн	Д.Хулан